



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/192/СТА-ТШЗ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН” УТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Т.ТӨРМӨНХ ТАНАА

2018.02.26 № 06/535  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт эгэх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\0226SAG3.Docx




## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ





**Аудитын код: САГ-2018/192/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор Ц.Энхжаргал  
Утас: 261740 Цахим хаяг: [enkhjargalts@audit.gov.mn](mailto:enkhjargalts@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн: "Лайэн Аудит" ХХК-ийн аудитор: Г.Дэлгэрцэцэг  
Утас: 7012 6778  
Цахим хаяг: [lionaudit@yahoo.com](mailto:lionaudit@yahoo.com)



Улаанбаатар хот



## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд САГ-2018/192/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар 2018 оны 1 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Лайэн аудит” ХХК-ийн аудитор Г.Дэлгэрцэцэг, аудиторын туслах Ү.Цэнджав нар хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тус хүрээлэнгийн захирлын 14 тоот албан бичгээр 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр “Лайэн аудит” ХХК-ийн туслах Ү.Цэнджав нар хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв.

### Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” /ХҮСХХ/ УТҮГ-ын эрхэм зорилго нь малын гаралтай түүхий эдийг боловсруулах, байгаль орчин ба хүний эрүүл мэндэд ээлтэй өндөр технологи хөгжүүлэх, мэдлэгийг баялаг болгох замаар эх орны хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулах юм.

Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх, сургалт, судалгаа явуулах, хөдөө орон нутагт малын гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрийг бий болгох, тэдгээрт тохирсон бага оврын техник, тоног төхөөрөмжийг зохион бүтээх, загварыг үйлдвэрлэх, ноос, ноолуурын түүхий эд болон нэхмэл бүтээгдэхүүнд үндэсний стандарт MNS-62, олон улсын ISO-28, IWTO-2, AATC-5, Woolmark-13 зэрэг нийт 114 стандартын дагуу чанарын сорил, шинжилгээг гүйцэтгэдэг хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухааны олон талт үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.


Аудитын явцад төсвийн шууд захирагч Т.Төрмөнхтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Татварын ерөнхий хуулиудыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

## Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хөрөнгийн алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотлоод олж авахыг тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан нийт 10 сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/



Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэлийг суурь болгон авч, түүний 1 хувиар тооцон материаллаг байдлын түвшинг 7,030.3 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “aculous” програм ашиглан санхүүгийн тайланг боловсруулж гаргасан байна.

#### **Тав. Дотоод хяналтын талаар**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын нэгжгүй учир дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.



#### **Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ 2017 онд нийт 457,776.2 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй, үүнээс улсын төсвөөс урсгал төсвийн санхүүжилтэд 456,276.2 мянга, үндсэн үйл ажиллагаанаас 7.7 мянган төгрөгийн орлого олж, төсвийн нийт гүйцэтгэлээр 456,144.3 мянган төгрөг зарцуулж, 809.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөвт зардлын санхүүжилт болон төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг сар тутам гаргаж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 1,631.9 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

БСШУС-ын сайдын 2017 оны А/48 дугаар тушаалаар тус хүрээлэнгийн төслөөс олох нэмэлт орлого, зардлын төсвийг нийт 194,300.0 мянган төгрөгөөр





баталсан боловч хүрээлэн 2017 онд 95,828.5 төгрөгийн орлого олж 95,766.3 мянган төгрөгийг зарцуулж 62.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Долоо. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

- ◆ Шилэн дансны цахим хуудас [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)-т 2017 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, 2018 оны төсвийн төсөл болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1 гүйлгээ буюу 14,633.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зэргийг байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

### **Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

### **Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар**



“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин болон бараа, ажил үйлчилгээний зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тус хүрээлэнд нийт 188,400.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл /үүнээс нийт 117,000.0 мянган төгрөгийн төсөвтэй 2 төсөл 2016-2018 онд хэрэгжих/ хэрэгжиж байгаа бөгөөд 2017 онд төслийн санхүүжилтээр нийт 71,451.3 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэх талаар**

Аудитын явцад “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТУГ-т мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:



1. **Авлагын талаар:** Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор ШУТИС-ийн харъяа Нэхмэлийн хүрээлэнг Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнтэй нэгтгэсэнтэй холбоотойгоор ШУТИС-ийн Ректорын 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Нэхмэлийн хүрээлэнгийн өөрийн орлогын ХХБ дахь 406001118 дугаар харилцах дансны үлдэгдэл 57,132.0 мянган төгрөгийг ШУТИС-ийн харъяа Үйлдвэр технологийн сургуулийн Голомт банкин дахь 8115007021 дугаар дансанд шилжүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасан байсныг шүүхийн шийдвэр гараагүй байхад ШУТИС-ийн удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн зөрчил арилгах 13 дугаар тогтоол болон тус хүрээлэнгийн захирлын 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тушаалаар авлагаас хасч өмнөх үеийн үр дүнг бууруулсан байна.

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3 дугаар бүлгийн 3.1.3-т "Шүүхийн шийдвэр болон хуулийн байгууллагын баримтаар төлөгдөх найдваргүй болох нь тогтоогдсон авлагыг жил бүрийн эцэст байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж данснаас хасна" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.


2. **Урьдчилж гарсан зардлын талаар:** Үндэсний аудитын газрын өгсөн албан шаардлагын дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн захирлын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн албан бичгийн дагуу 2016-2018 онд хэрэгжих 2 төслийн 2016-2017 оны зардал 48,761.8 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэснийг тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, аудитын явцад алдааг залруулсан болно.

3. **Урьдчилж орсон орлогын талаар:** 2016-2018 онд хэрэгжих 2 төсөлтэй холбогдон гарсан зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн болон төслийн санхүүжилт 48,761.8 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэлгүй тайлант жилд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.6-д "зохицох зарчим баримтална" гэж заасныг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, аудитын явцад алдааг залруулсан болно.

4. **Бараа материалын талаар:** Урсгал засварын зардалд 1,234.8 мянган төгрөгийн үнэ бүхий дрож, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардалд 2,580.0 мянган төгрөгийн үнэ бүхий шилэн хаалт, 920.0 мянган төгрөгийн бутлагч, бараа үйлчилгээний бусад зардалд 525.0 мянган төгрөгийн электрон жин, нийт 5,259.8 мянган төгрөгийн хангамжийн материалыг шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3 дугаар бүлгийн 3.1.4-т "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад буюу нэг жилийн дотор сургалт болон бусад үйлчилгээ, захиргааны зориулалтаар ашиглагдах хангамжийн зүйлс, сэлбэг хэрэгсэл болон худалдахаар эзэмшиж буй биет үндсэн хөрөнгийг хэлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 388 дугаар тушаал болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, аудитын явцад алдааг залруулсан болно.

#### **Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитаар Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор ШУТИС-ийн харьяа Нэхмэлийн хүрээлэнг Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнтэй нэгтгэсэнтэй холбоотойгоор ШУТИС-ийн Ректорын 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Нэхмэлийн хүрээлэнгийн өөрийн орлогын ХХБ дахь 406001118 дугаар харилцах дансны үлдэгдэл 57,132.0 мянган төгрөгийг ШУТИС-ийн харьяа Үйлдвэр технологийн сургуулийн Голомт банкин дахь 8115007021 дугаар дансанд шилжүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасан байсныг шүүхийн шийдвэр гараагүй байхад ШУТИС-ийн удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн зөрчил арилгах 13 дугаар тогтоол болон тус хүрээлэнгийн захирлын 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тушаалаар авлагаас хасч өмнөх үеийн үр дүнг бууруулсныг залруулах боломжгүй байна.

#### **Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

#### **Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

"Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн" УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.



**Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 159,915.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 102,783.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулж, 57,132.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэх.

**Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баян суварга аудит” ХХК хийж 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөнийг 100 хувь биелүүлсэн байна.

**Арван зургаа. Зөрчилгүй санал дүгнэлт**

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитын тайланд хавсралт материал /8 хуудас/-ыг хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

Хянасан:



Аудитор

Г.Дэлгэрцэцэг

Бэлтгэсэн:

Аудиторын туслах



Ү.Цэнджав

Огноо:2018.02.26

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



**Асуудал 1. Авлагын талаар**

**Тархуулах ач холбогдол № 1**

**ҮАГ-ын ажиглалт**

Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор ШУТИС-ийн харъяа Нэхмэлийн хүрээлэнг Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнтэй нэгтгэсэнтэй холбоотойгоор ШУТИС-ийн Ректорын 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн А/81 дугаар тушаалаар Нэхмэлийн хүрээлэнгийн өөрийн орлогын харилцах дансны үлдэгдэл 57,132.0 мянган төгрөгийг ШУТИС-ийн харъяа Үйлдвэр технологийн сургууль руу шилжүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасан байсныг шүүхийн шийдвэр гараагүй байхад ШУТИС-ийн удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн зөрчил арилгах 13 дугаар тогтоол болон тус хүрээлэнгийн захирлын 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тушаалаар авлагаас хасч өмнөх үеийн үр дүнг бууруулсан байна.

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3 дугаар бүлгийн 3.1.3-т "Шүүхийн шийдвэр болон хуулийн байгууллагын баримтаар төлөгдөх найдваргүй болох нь тогтоогдсон авлагыг жил бүрийн эцэст байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж данснаас хасна" гэж заасныг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

**ҮАГ-ын зөвлөмжүүд**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлдвэрийн аудитын байгууллага  
01 Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дугаардан төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01 ТӨРНИЙ АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТҮГ-ЫН  
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-ний өдөр

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	-	
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		
<b>АВЛАГА</b>	<b>57 132 000,00</b>	-
Бусад авлага	57 132 000,00	
<b>УРЬДЧИЛГАА</b>	-	<b>48 761 800,00</b>
Урьдчилж гарсан зардал		48 761 800,00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>34 749 144,36</b>	<b>28 053 699,59</b>
Түүхий эд материал	7 581 955,59	9 468 895,59
Бэлэн бүтээгдэхүүн	10 586 000,00	7 474 000,00
Хангамжийн материал	16 581 188,77	11 110 804,00
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>91 881 144,36</b>	<b>76 815 499,59</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>678 448 329,40</b>	<b>774 205 727,86</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>677 616 329,34</b>	<b>771 877 727,76</b>
Барилга, байгууламж	221 836 141,49	221 836 141,49
Хуримтлагдсан элэгдэл	(84 445 994,24)	(90 825 140,00)
Авто тээврийн хэрэгсэл	18 753 179,40	18 753 179,40
Хуримтлагдсан элэгдэл	(18 753 179,40)	(18 753 179,40)
Машин, тоног төхөөрөмж	1 025 771 432,12	1 321 622 204,12
Хуримтлагдсан элэгдэл	(498 731 414,96)	(697 915 627,34)
Тавилга, аж ахуйн эд хогшил	40 166 917,61	41 461 491,61
Хуримтлагдсан элэгдэл	(26 980 752,68)	(24 301 342,12)
Номын фонд	293 000,00	293 000,00
Бусад хөрөнгө	140 000,00	140 000,00
Хасагдуулга	(140 000,00)	(140 000,00)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>539 000,06</b>	<b>2 035 000,10</b>
Програм хангамж	770 000,00	2 420 000,00
Хасагдуулга	(230 999,94)	(384 999,90)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>678 448 329,40</b>	<b>774 205 727,86</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>770 329 473,76</b>	<b>851 021 227,45</b>
Богино хугацаат өр төлбөр	-	-
Өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	-	48 761 800,00
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>48 761 800,00</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>48 761 800,00</b>
Засгийн газрын оруулсан капитал	126 077 747,68	126 077 747,68
Өмнөх үеийн үр дүн	818 606 889,54	584 218 233,27
Тайлант үеийн үр дүн	(177 256 656,27)	89 061 953,69
Дахин үнэлгээний зөрүү	2 901 492,81	2 901 492,81
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>770 329 473,76</b>	<b>802 259 427,45</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>770 329 473,76</b>	<b>802 259 427,45</b>

**01**

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**01**

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН  
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

2017 оны 12 сарын 31-ний өдөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b>ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>501 475 050,00</b>	<b>518 613 880,00</b>
Улсын төсвөөс	420 793 300,00	422 785 400,00
Урсгал	<b>80 681 750,00</b>	<b>95 828 480,00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		2 003 810,00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс		
доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	80 681 750,00	93 824 670,00
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>1 284 400,00</b>	<b>274 497 048,00</b>
<b>Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого</b>	<b>1 284 400,00</b>	<b>274 497 048,00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлого		677 700,00
Үнэ төлбөргүй авсан орлого	<b>502 759 450,00</b>	<b>793 110 928,00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>381 665 531,00</b>	<b>376 838 190,00</b>
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	<b>344 811 078,00</b>	<b>338 990 997,00</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	344 811 078,00	338 990 997,00
Цалин	<b>36 854 453,00</b>	<b>37 847 193,00</b>
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>31 128 163,00</b>	<b>31 737 007,00</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	24 233 143,00	24 765 023,00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	2 825 770,00	2 875 341,00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3 498 133,00	3 493 016,00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	571 117,00	603 627,00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5 726 290,00	6 110 186,00
Эрүүл мэндийн даатгалын хураамж		
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14 840 000,00</b>	<b>14 544 264,00</b>
<b>Тогтмол зардал</b>	<b>4 726 721,00</b>	<b>3 836 243,00</b>
Гэрэл цахилгааны зардал	8 177 771,00	7 784 913,00
Түлш, халаалтын зардал	1 935 508,00	2 923 108,00
Цэвэр, бохир усны зардал	<b>7 591 118,00</b>	<b>9 108 840,00</b>
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>1 691 400,00</b>	<b>1 685 300,00</b>
Бичиг хэргийн материал	400 000,00	-
Тээвэр, шатахууны зардал	4 249 955,00	4 628 107,00
Шуудан холбооны зардал	150 000,00	117 000,00
Ном, хэвлэлийн зардал	1 099 763,00	2 678 433,00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	<b>1 660 000,00</b>	<b>650 000,00</b>
<b>Нормативт зардал</b>	<b>1 660 000,00</b>	<b>650 000,00</b>
Нормын хувцас зөөлөн эдлэл	<b>6 683 030,00</b>	<b>10 924 228,00</b>
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>223 220,00</b>	<b>1 941 220,00</b>
Багаж хэрэгсэл	6 459 810,00	8 983 008,00
Урсгал засвар	2 509 000,00	2 567 200,00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2 509 000,00</b>	<b>2 567 200,00</b>
Дотоод томилолтын зардал		
Гадаад томилолтын зардал		
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ</b>	<b>40 116 806,00</b>	<b>41 150 614,00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	2 000 000,00	400 000,00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	<b>220 395 980,27</b>	<b>233 970 986,56</b>
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16 744 494,00</b>	<b>23 376 264,77</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	203 651 486,27	210 594 721,79
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	<b>2 554 641,00</b>	<b>12 271 746,00</b>
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1 900 000,00</b>	<b>11 400 000,00</b>
Бусад урсгал шилжүүлэг		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1 900 000,00	900 000,00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		10 500 000,00
Төвлөрүүлэн шилжүүлэг	654 641,00	871 746,00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>680 016 106,27</b>	<b>703 026 068,56</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(177 256 656,27)</b>	<b>90 084 859,44</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1 022 905,75
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>1 022 905,75</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(177 256 656,27)</b>	<b>89 061 953,69</b>

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН  
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

0

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>501,475,050.00</b>	<b>552,104,680.00</b>
Улсын төсвөөс	420,793,300.00	456,276,200.00
Урсгал	420,793,300.00	456,276,200.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>80,681,750.00</b>	<b>95,828,480.00</b>
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт	-	2,003,810.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	80,681,750.00	93,824,670.00
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>11,016,819.00</b>	<b>16,022,394.00</b>
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	1,284,400.00	677,700.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,284,400.00	677,700.00
Туслах үйл ажиллагааны орлого	6,880,788.00	10,700,566.00
Нийгмийн даатгалын сангаас	2,851,631.00	4,644,128.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>512,491,869.00</b>	<b>568,127,074.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>484,511,608.00</b>	<b>522,299,650.00</b>
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	<b>384,517,162.00</b>	<b>381,482,318.00</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>347,662,714.00</b>	<b>343,635,125.00</b>
Цалин	347,662,714.00	304,128,725.00
Бусад нэмэгдлүүд		24,870,000.00
Унаа, болон бусад нөхөн олговор		14,636,400.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,854,448.00</b>	<b>37,847,193.00</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	31,128,161.00	31,737,007.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,233,141.00	24,765,023.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,825,770.00	2,875,341.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,498,133.00	3,493,016.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	571,117.00	603,627.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,726,287.00	6,110,186.00
<b>Бараа үйлчилгээний урсгал зардал</b>	<b>99,994,346.00</b>	<b>140,817,332.00</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,840,000.00</b>	<b>14,544,264.00</b>
Гэрэл цахилгааны зардал	4,726,721.00	3,836,243.00
Түлш, халаалтын зардал	8,177,771.00	7,784,913.00
Цэвэр, бохир усны зардал	1,935,508.00	2,923,108.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,663,268.00</b>	<b>9,217,840.00</b>
Бичиг хэргийн материал	1,795,400.00	1,785,200.00
Тээвэр, шатахууны зардал	400,000.00	
Шуудан холбооны зардал	4,249,955.00	4,628,107.00
Ном, хэвлэлийн зардал	150,000.00	117,000.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	1,067,913.00	2,687,533.00
<b>Нормативт зардал</b>	<b>1,660,000.00</b>	<b>650,000.00</b>
Нормын хувцас зөөлөн эдлэл	1,660,000.00	650,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,490,030.00</b>	<b>11,106,658.00</b>
Багаж хэрэгсэл	898,220.00	887,900.00
Урсгал	6,591,810.00	10,218,758.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,509,000.00</b>	<b>2,567,200.00</b>
Дотоод томилолтын зардал	2,509,000.00	2,567,200.00
Гадаад томилолтын зардал		
Гадаадын зочны зардал		
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ</b>	<b>49,045,106.00</b>	<b>71,718,454.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,045,106.00	71,258,454.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	460,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,786,942.00</b>	<b>31,013,916.00</b>
Бусад зардал	16,786,942.00	31,013,916.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,554,641.00</b>	<b>12,271,746.00</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг		
Бусад урсгал шилжүүлэг	1,900,000.00	900,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,900,000.00	900,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		10,500,000.00

01 ТӨВИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Төвлөрүүлэн шилжүүлэг	654,641.00	871,746.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>487,066,149.00</b>	<b>534,571,396.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>25,425,720.00</b>	<b>33,555,678.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>25,425,720.00</b>	<b>33,555,678.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,425,720.00	33,555,678.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>25,425,720.00</b>	<b>33,555,678.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(25,425,720.00)</b>	<b>(33,555,678.00)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН  
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>126,077,747.68</b>	<b>2,901,492.81</b>	<b>818,606,889.54</b>	<b>947,586,130.03</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	818,606,889.54	947,586,130.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(177,256,656.27)	(177,256,656.27)
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>126,077,747.68</b>	<b>2,901,492.81</b>	<b>641,350,233.27</b>	<b>770,329,473.76</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(57,132,000.00)	(57,132,000.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,077,747.68	2,901,492.81	584,218,233.27	713,197,473.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			89,061,953.69	89,061,953.69
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>126,077,747.88</b>	<b>2,901,492.81</b>	<b>673,280,186.96</b>	<b>802,259,427.45</b>

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>467,776,200.00</b>	<b>466,144,346.00</b>	<b>1,631,854.00</b>	<b>100</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>467,776,200.00</b>	<b>466,144,346.00</b>	<b>1,631,854.00</b>	<b>100</b>
Бараа ажил үйлчилгээний зардал	447,276,200.00	445,644,346.00	1,631,854.00	100
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,473,800.00	320,470,534.00	3,266.00	100
Үндсэн цалин	280,968,000.00	280,964,134.00	3,866.00	100
Нэмэгдэл	24,889,600.00	24,870,000.00	(400.00)	
Унаа хоолны хөнгөлөлт	14,636,200.00	14,636,400.00	(200.00)	
Урамшуулал				
Гэрээт ажлын цалин				
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,003,100.00</b>	<b>35,954,248.00</b>	<b>48,852.00</b>	<b>100</b>
Тэтгэвэрийн даатгал	23,168,189.00	23,370,922.00	(202,733.00)	101
Тэтгэмжийн даатгал	2,647,794.00	2,745,858.00	(97,864.00)	104
ҮОМШӨ-ийн даатгал	3,309,738.00	3,313,223.00	(3,485.00)	100
Ажилгүйдлийн даатгал	661,944.00	579,951.00	81,993.00	88
Эрүүл мэндийн даатгал	6,215,435.00	5,944,494.00	270,941.00	96
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,584,000.00</b>	<b>14,544,264.00</b>	<b>39,736.00</b>	<b>100</b>
Гэрэл цахилгаан	5,204,000.00	3,836,243.00	1,367,757.00	74
Түлш халаалт	7,520,000.00	7,784,913.00	(264,913.00)	104
Цэвэр бохир ус	1,860,000.00	2,923,108.00	(1,063,108.00)	157
Байрны түрээс				
Хангамж, бараа материалын зардал	196,800.00	196,800.00		100
Бичиг хэрэг	150,000.00	35,200.00	114,800.00	23
Тээвэр шатахуун				
Шуудан холбоо интернэтийн төлбөр				
Ном хэвлэл				
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал				
Бага үнэтэй тургэн элэгдэх ахуйн эд зүйлс	46,800.00	161,600.00	(114,800.00)	345
Нормативт зардал				
Эм, бэлдмэд, эмнэлгийн хэрэгсэл				
Хоол, хүнс				
Нормын хувцас зөөлөн эдлэл				
Эд хогшил, урсгал засварын зардал				
Багаж техник хэрэгсэл				
Тавилга				
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл				
Урсгал засвар				
Томиллолт, зочны зардал	2,567,200.00	2,567,200.00		100
Гадаад албан томиллолт				
Дотоод албан томиллолт	2,567,200.00	2,567,200.00		100
Зочин хүлээн авах зардал				
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>73,451,300.00</b>	<b>71,911,300.00</b>	<b>1,540,000.00</b>	<b>98</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,451,300.00	71,451,300.00		100
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	460,000.00	1,540,000.00	23
Даатгалын үйлчилгээ				
Тээврийн хэрэгслийн татавар				
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				
Газрын төлбөр				
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,500,000.00</b>	<b>10,500,000.00</b>		
Бусад урсгал шилжүүлэг	10,500,000.00	10,500,000.00		
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	10,500,000.00	10,500,000.00		
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>				
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>				
Төсвийн хөрөнгөөр санхүүжих ХО барилга байгууламж				
Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж				
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>467,776,200.00</b>	<b>466,144,346.00</b>	<b>1,631,854.00</b>	<b>100</b>
Төсвөөс олгосон санхүүжилт	456,276,200.00	457,431,100.00	(1,154,900.00)	100
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,500,000.00	677,700.00	822,300.00	45
Туслах үйл ажиллагааны орлого				
Хөрөнгө оруулалтын санхүүжилт				
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	<b>35.00</b>	<b>35.00</b>	<b>-</b>	<b>100</b>
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100
Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	-	100
Үйлчлэх ажилтан				
Гэрээт ажилтан				

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САЛГАЛ ДҮГНЭЭТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САЛГАЛ ДҮГНЭЭТ

"ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН" УТУГ-ЫН 2017 ОНЫ НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>				
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>				
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>57,814,780.00</b>	(57,814,780.00)	
Бүлгийн дүнгээр хянагддаг зардлууд	-	29,434,448.00	(29,434,448.00)	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	18,520,463.00	(18,520,463.00)	
Үндсэн цалин	-	18,520,463.00	(18,520,463.00)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,892,945.00	(1,892,945.00)	
Тэтгэвэрийн даатгал		1,394,101.00	(1,394,101.00)	
Тэтгэмжийн даатгал		129,683.00	(129,683.00)	
ҮОМШӨ-ийн даатгал		179,793.00	(179,793.00)	
Ажилгүйдлийн даатгал		23,676.00	(23,676.00)	
Эрүүл мэндийн даатгал		165,692.00	(165,692.00)	
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	-	-	
Хангамж, бараа материалын зардал	-	9,021,040.00	(9,021,040.00)	
Бичиг хэрэг		1,750,000.00	(1,750,000.00)	
Тээвэр шатахуун				
Шуудан холбоо интернэтийн төлбөр		4,628,107.00	(4,628,107.00)	
Ном хэвлэл		117,000.00	(117,000.00)	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал				
Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс		2,525,933.00	(2,525,933.00)	
<b>Нормативт зардал</b>				
Эм, бэлдмэд, эмнэлгийн хэрэгсэл				
Хоол, хүнс				
Нормын хувцас зөөлөн эдлэл		650,000.00	(650,000.00)	
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>				
Багаж техник хэрэгсэл		4,420,400.00	(4,420,400.00)	
Тавилга				
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл				
Урсгал засвар		10,217,758.00	(10,217,758.00)	
<b>Томиллолт, зочны зардал</b>	-	-	-	
Гадаад албан томиллолт				
Дотоод албан томиллолт				
Зочин хүлээн авах зардал				
<b>Зардлын зүйл тус бүрээр хянагдах тогтмол зардлууд</b>	-	<b>28,180,332.00</b>	(28,180,332.00)	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		28,180,332.00	(28,180,332.00)	
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох				
Даатгалын үйлчилгээ				
Тээврийн хэрэгслийн татвар				
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				
Газрын төлбөр				
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>900,000.00</b>	(900,000.00)	
Бусад урсгал шилжүүлэг				
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		900,000.00	(900,000.00)	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>95,766,288.00</b>	(95,766,288.00)	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,003,810.00	(2,003,810.00)	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		93,762,478.00	(93,762,478.00)	
Туслах үйл ажиллагааны орлого				
Хөрөнгө оруулалтын санхүүжилт				
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	
<b>Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>				
Удирдах ажилтан	35.00			100
Гүйцэтгэх ажилтан	1.00			100
Үйлчлэх ажилтан	34.00			100
Гэрээт ажилтан				

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**01** **ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**01** **ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл

2017 оны 12 сарын 31

№	Сорил хийсэн дансны нэр	Аудитаар илэрсэн асуудал	Мөнгөн дүн	Залруулсан	Зөвлөмж хүргүүлэх	Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө	Аудиторын санал (Бүртгэлийн бичилт, тооцоолол)	Тухайн байгууллагын санал	Уулзалтын үр дүнгийн баталгаажуулалт
1	Авлага	Бусад авлагыг шүүхийн шийдвэр гараагүй байхад ШУТИС-ийн удирдах зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн зөрчил арилгах 13 дугаар тогтоол болон тус хүрээлэнгийн захирлын 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тушаалаар авлагаас хасч өмнөх үеийн үр дүнг бууруулсан	57,132,000		57,132,000	Материаллаг	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах	Зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.	Аудитын зөвлөмж өгөхөөр тогтов.
2	Урьдчилж гарсан зардал	Үндэсний аудитын газрын өгсөн албан шаардлагын дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн захирлын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн захирамжтай уявд хамтаар дагуу 2016-2017 онд хэрэгжих 2 төслийн 2016-2017 оны зардал 48,761.8 мянган урьдчилж гарсан зардал дансанд бүртгэснийг тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулсан	48,761,800	48,761,800		Материаллаг	Төсөл хариуцагч нартай тооцоо нийлсэн акт хийх	Зөвшөөрч залруулав	Аудитын зөвлөмж өгөхөөр тогтов.
3	Урьдчилж орсон орлого	2016-2018 оны 2 төсөлтэй холбогдон урьдчилж бүртгэсэн санхүүжилт төгрөгийг орлогоор бүртгэсэн	48,761,800	48,761,800		Материаллаг	Төслийн санхүүжилт урьдчилж орсон орлогоор бүртгэх	Зөвшөөрч залруулав	Аудитын зөвлөмж өгөхөөр тогтов.

БҮРТГЭЛ  
САНАЛ ДҮГНЭЭТ

4	Барaa материал	Урсгал засварын зардалд 1,234.8 мянган төгрөгийн үнэ бүхий дрозж, бусдаар гүйцэтүүлсэн ажлын зардалд 2,580.0 мянган төгрөгийн үнэ бүхий шилэн хаалт, 920.0 мянган төгрөгийн бутлагч, бараа үйлчилгээний бусад зардалд 525.0 мянган төгрөгийн электрон жин, нийт 5,259.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зардалд бүртгэсэн	5,259,750	5,259,750	Материаллаг бус	Барaa материалд бүртгэж авах	Зөвшөөрч залруулав	Аудитын зөвлөмж өгөхөөр тогтов.
		Дун	159,915,350	102,783,350	57,132,000			

Г.Дэлгэрцэцэг

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл хөтөлсөн аудитор

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн:

Захирал... Т.Болормаа Терменх

Нягтлан бодогч: Т.Болормаа

Анхан шатны хяналт хийсэн аудитын менежер:

Хоёрдох шатны хяналт хийсэн төрүүлэх аудитор:

Баянтосмуулсан 2018.02.28.  
Хичуулсан нь 2018.03.01 нтг.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



Ажлын баримтын нэр: **Залруулаагүй буруу шэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл**

Илгээгдсэн байгууллагын нэр: **Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн**

Аудитын нэр: **2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит**

Аудитын юр: **САГ-2018/192/СТА-ТШЗ**

Мөн төлөгчөөн

Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийгээсэн байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харуу, тайлбар	Гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудлыг хармуулах хүрнэг	Албар, тулбарал	Овог нэр
Алага	13	Байгууллагаас авах авлагад бүртгэлтэй байсан 57,132.0 мянган төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр гараагүй байхад ШУТИС-ийн удирдах зөвлөлийн 2017.06.12-ны өдрийн зөрчил арилгах 13 дугаар тогтоол болон тус хүрээлэнгийн захирлын 2017.06.15-ны өдрийн 47 дугаар тушаалаар авлагаас хасгасан өмнөх үеийн үр аүйг бууруулсан байна.	57,132	Зөвлөмж өгөх			Зөвлөмж өгөх			
Дүн			57,132							

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ САГАЛ ДҮГНЭЛТ**

Бэлтгэсэн: *Лувсан*

Аудиторын туслах: *Лувсан* ..... Ү.Цэнхэр

Анхан шатанд ханасан: *Лувсан*

Аудитор: *Лувсан* ..... Г.Дэлгэрцэцэг

Хоёр дахь шатанд ханасан: *Лувсан*

Албан тушаал, овог нэр, гарын үсэг: *Лувсан* ..... Т.Болормаа

Танилцаж зөвшөөрсөн: *Лувсан*

Захирал: *Лувсан* ..... 1115103103 5907888

Ерөнхий нягтлан бодогч: *Лувсан* ..... Т.Болормаа

Огноо: Огноо

Огноо: Огноо

Огноо: Огноо

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

